**Төслийн нэр: “Нутгийн баялаг – бидний бахархал”**

**Хэсэг I:** Төсөл санаачлагчийн мэдээлэл

| |
|---|
| Аймаг/ хот: Сүхбаатар аймаг |
| Сум /дүүрэг: Сүхбаатар сум |
| Сургууль, СЭЭБХ-ны хаяг: Сургуулийн 4 тоот |
| СЭЭБХ-ны зохицуулагчийн овог, нэр: Бүргэдээ овогтой Эрдэнэчимэг |

**Хэсэг IIa.** Нөхцөл байдлын шинжилгээ

| **Дотоод хүчин зүйлс** | |
|---|---|
| Давуу тал:<br>1. Танин мэдэхүйн<br>2. Хөгжих<br>3. Анги дүүргэлт 20-28 сурагчтай учир АУБ хүүхэд, эцэг эх нэг бүртэй ажиллах боломжтой<br>4. Нэг ээлжээр хичээллэдэг | Сул тал:<br>1. Орон нутгийн баялгийг судлах цаг хичээлд тусгагдаагүй<br>2. Иргэд нутгийнхаа байгалийн баялгийг мэддэггүй.<br>3. Ухуулга сурталчилгаа муу байдаг.<br>4. Хайрлан хамгаалах сэтгэлгээ сул \Иргэд, төрийн ба төрийн бус байгууллагууд\<br>5. Сургуулийн хувьд 5-р багийн хамрагдалт бага байдаг учир тус багийн нутаг дэвсгэр дээрх байгалийн баялгийг олж цуглуулахад хүндрэлтэй |
| **Гадаад хүчин зүйлс** | |
| Боломж:<br>1. Сумын иргэд бие биенээ сайн таньдаг<br>2. Байгалийн баялаг ихтэй | Эрсдэл:<br>1. Эцэг эхчүүдийн идэвх оролцоо сул |

- Давуу талаа бататгахад чиглэсэн үйл ажиллагаа
  - Сурагчид эцэг эхтэйгээ хамтран өөрийн амьдарч буй ажиглах, судлах,
  - “Миний нутгийн гайхамшиг” сэдэвт ярилцлага зохион байгуулах
- Сул талаа давуу тал болгоход чиглэсэн үйл ажиллагаа
  - Сурах бичигт тусгагдсан агуулгыг өөрийн орон нутгийн онцлогтой холбон судлах
  - Нутгийнхаа баялгийг бусдад сурталчлан ярьж, таниулах, гарын авлага гаргах
- Эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа
  - Эцэг эхийн хувьд хүүхдээ зөвхөн сургуульд бус амьдарч буй орчиндоо хамтран суралцаж, хөгжүүлж болно гэдгийг ухаарах
- Боломжийг ашиглахад чиглэсэн үйл ажиллагаа
  - Хүүхэд нь гэртээ аав, ээж, эмээ, өвөө гэх мэт хүмүүстэй нутаг орныхоо тухай ярилцах, ярилцах явцдаа газар усныхаа түүх домог, бүтцийг ойлгож мэдлэг бүтээх чадварт суралцана.

**Хэсэг IIб.** Төслийн зорилго, хамрах хүрээ

| | |
|---|---|
| Зорилго | Байгалийн ухааны хичээлийн агуулгаар дамжуулан орон нутгийн талаар нэмэлт мэдлэг олгож, эцэг эхийн оролцоотой унших, бичих, ярих чадварыг ахиулна. |
| Хамрагдах хүний тоо | Төслийн үр шимийг хүртэгчдийн тоо: 269 сурагч, бага боловсролын 11 багш, 187 эцэг эх, СЭЭБХ-ны гишүүд, сургуулийн удирдлага байна |

**Хэсэг III.** Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө
Хүрэх үр дүн :

- Орон нутгийн байгалийн баялгийг ашиглаж, унших гарын авлага боловсруулах

- Боломжит баялгийг биет байдлаар авчирч байршуулж музей байгуулж, сургалтад ашиглах, ***СЭЭБХ-ны гишүүн эцэг эх цаашид баяжуулж, арчлан ажиллах, өөрсдийн туршлагаа сумын болон бусад эцэг эх, иргэдэд сурталчлах үйл ажиллагааг хариуцна.***

| ДД | Үйл ажиллагаа | Хариуцах эзэн | Хугацаа | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|
| 1. | Төслийн нээлтийн үйл ажиллагаа | СЭЭБХ-ны Удирдах зөвлөл | 2019 оны 6-р сар | • Сумын, сургуулийн удирдлага, сумын бусад иргэд, эцэг эх, малчин эцэг эхэд төслийн болон СЭЭБХ-ны үйл ажиллагааг танилцуулах, хийсэн ажлын тайланг тавьж, гишүүнчлэлээ нэмэгдүүлнэ. |
| 2. | Байгаль хамгаалагч 1-5-р ангийн сурагчидтай уулзалт | СЭЭБХ-ны Удирдах зөвлөл | 2019 оны 9-р сар | • Сумын байгаль хамгаалагч Ганбулганыг урьж сурагчдад сумынхаа газар нутаг, уул хөшөө дурсгалын талаарх түүх, домог, хууч ярианы талаар ярилцаж, мэдлэг бүтээх |
| 3. | • 1-р анги “Газар усны нэр тогтоох”<br>• 2, 3-р анги “Миний нутаг – миний бахархал” сэдвийн дор төрсөн сэтгэгдлээ илэрхийлэн бичих, ярих<br>• 4-5 анги “Миний хөдөө” сэдвийн дор өдрийн тэмдэглэл хөтлөх | СЭЭБХ-ны Удирдах зөвлөл, АУБ нар | 2019 оны 10-р сараас | • 1 дүгээр ангийн сурагчид эцэг эхтэйгээ хамтран орон нутагтаа байгаа байгалийн үзэсгэлэнт газруудын нэрийг тогтоох, зургаар илэрхийлж ярих, тайлбарлах (зурсан зургуудыг бяцхан номд ашиглана)<br>• 2, 3-р ангийн сурагчид эцэг эхийн хамт сумын ойролцоох 10 км доторх уул, булаг, хөшөө, дурсгалыг аяллаар явж үзэж судлах, тэдгээрийн түүхийг мэддэг болох, төрсөн сэтгэгдлээ илэрхийлэн ярих, бичих, зурах даалгавар өгнө (зураг, бичвэрийг бяцхан номд ашиглана)<br>• 4, 5-р ангийн сурагчид эцэг эхийн хамт 4-р сард сумын сайн малчнаыд “Малчны хотонд нэг өдөр” өдөрлөгийг зохион байгуулж, өдрийн тэмдэглэл хөтлөх, зохион бичлэг бичих, зурах, баримлын шавраар бүтээх даалгавар өгнө (бүтээлүүдийг бяцхан номд ашиглана) |
| 4. | ССДА-ыг хэрэгжүүлэх, тайлан бичих, уулзалт зохион байгуулах | СЭЭБХ-ы Удирдах зөвлөлийн гишүүд | 2019 оны 9-10-р сар | Сургуулийн удирдлага, иргэдэд сургуулийн цогц орчны нөхцөл байдлын талаар танилцуулж, сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах ажлуудыг санал болгоно.<br>Сургуулийн түвшинд шийдвэрлэх боломжгүй асуудлаар сум, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | аймгийн түвшинд шийдүүлэх асуудлаар зөвшилцөнө. |
| 5. | Сургуулиа дэмжих үйл ажиллагаа | СЭЭБХ | 2019.12 -2020.2 | 3 орчноор үйл ажиллагаа явуулна. |
| 6. | Сумын түвшинд нөлөөллийн уулзалт зохион байгуулна. | СЭЭБХ-ы Удирдах зөвлөл, гишүүд, сургуулийн удирдлагын баг | 2019 оны 11-р сард | ССДА-ыг хэрэгжүүлсэн үнэлгээнээс сургуулийн түвшинд шийдвэрлэх боломжгүй асуудлаар сумын удирдлагуудтай нөлөөллийн уулзалт зохион байгуулна. |
| 7. | “Миний сайхан нутаг” музейн зураглал гаргах, үүний дагуу материал цуглуулах | СЭЭБХ-ы Удирдах зөвлөлийн гишүүд | Зуны амралтаар даалгавар өгнө | Анги тус бүрийн багш, сурагчид өгөгдсөн сэдвийн дагуу эцэг эх, эмээ өвөөгөөс мэдээлэл (цэцэг, ургамлын хатаамал, амьтад, газар усыг зурж)-ийг бэлтгэж ирнэ. |
| 8. | Анги бүр авсан сэдвээр “Бидний бяцхан ном” хийх | СЭЭБХ-ы Удирдах зөвлөлийн гишүүд, АУБ | 2019 оны 9-р сард | Эцэг эх хүүхэдтэйгээ хамтран өвс ургамлын хатаамал, амьтад, газар усыг зургаар баримтжуулан (жижигрүүлсэн загвар) танилцуулгыг дээрх сэдвийн дагуу АУБ нартай хамтран гарын авлага хийх |
| 9. | “Миний сайхан нутаг” музей байгуулах | СЭЭБХ-ы Удирдах зөвлөлийн гишүүд, АУБ | 2019 оны 9-10-р сард | Төслийн хугацаанд цуглуулсан материалуудаар сургуульдаа музей байгуулна. Сурагчдын бүтээлийг 2018 оны 1-р ангийн сурагч ....овогтой ..... үүнийг бүтээлээ гэх мэтээр тайлбар бичиж, жил бүр баяжуулна. |
| 10. | Аймгийн “Харилцан суралцъя” чуулганд бэлтгэх, оролцох | СЭЭБХ-ы Удирдах зөвлөлийн гишүүд | 2020 оны 3-р сард | Аймгийн бусад СЭЭБХ-ноос суралцах, туршлага солилцох, хамтран ажиллах мөн аймгийн удирдлагуудад сургуулийн асуудлаа танилцуулж шийдвэрлүүлэх үйл ажиллагаанд оролцож чадавхжина. |
| 11. | Тайлант өдөрлөг | СЭЭБХ, ЕБС-ийн бага боловсро-лын багш нар | 2020 оны 4-р сард | Сургалтад ашигласан үзүүлэн материал, сурагчдын зуны даалгаврын бүтээл зэргийг биет байдлаар танилцуулах, шилдэг хамт олныг шалгаруулж урамшуулах |
| 12. | Музейг баяжуулах, сурталчлах | СЭЭБХ-ы Удирдах зөвлөлийн гишүүд, АУБ, сургалтын менежер | 2020-2021 оны хичээлийн жилд | Өөрийн сумын болон ойролцоо сумын удирдлагууд, иргэдийг урьж музейгээ үзүүлнэ. Үүнд сурагчид ээлжлэн музейн тайлбарлагч хийнэ.<br>СЭЭБХ-ны гишүүн эцэг эх энэ дашрамд СЭЭБХ-ны үйл ажиллагаагаа танилцуулна. |

**Хэсэг IV.** Зардлын задаргаа

| Зардлын төрөл | | Хэмжих нэгж | Тоо | Нэг бүрийн үнэ, төг | Нийт үнэ, төг | Тус бүрт нь хүрэх үр дүнг бичнэ. (Хүүхдэд ямар бодит үр дүн авчрах, ямар чадварыг эзэмшүүлэх) |
|---|---|---|---|---|---|---|
| Сургалтын хэрэглэгдэх | Бичиг хэрэг | | | | 100,000 | ССДА-ыг хэрэгжүүлэх хамтарсан багийн ойлголт нэгтгэх сургалт, сурагчдад зориулсан сургалт, уулзалт, бяцхан ном бүтээхэд ашиглана. |
| | Баннер | ш | 2 | 50,000 | 100,000 | |
| ССДА хэрэгжүүлэх зардал | Сургуулийн 3 орчныг үнэлэх, тайлан бичих үйл явцын зардал | | | | 150,000 | Эцэг эх, багш, сурагч, аймаг, сум, сургуулийн удирдлагын төлөөлөл багаар ажиллах, цуглуулсан мэдээлэлд анализ хийх, нэгтгэн дүгнэх, тайлан бичих чадварт суралцана. |
| | Сургуулиа дэмжих үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах явцын зардал | | | | 450,000 | |
| Сургалт, чуулга уулзалт | Төслийн нээлтийн үйл ажиллагаа | 1 удаа | 100 хүн | 2000 | 200,000 | Эцэг эх чадавжиж, оролцоо нэмэгдсэнээр сурагчдын унших, бичих, ярих чадвар сайжирч сурлагын амжилтад нөлөөлнө. |
| | Тайлант өдөрлөг | 1 удаа | 100 хүн | 2000 | 200,000 | |
| | Сургалт | 1 удаа | 200 хүүхэд | 1200 | 240,000 | Сумын байгаль хамгаалагч Ганбулган сурагчидтай сумынхаа газар нутаг, уул хөшөө дурсгалын талаарх түүх, домог, хууч ярианы талаар ярилцаж мэдлэг бүтээнэ. |
| | 2, 3-р ангийн аялал | 1 удаа | 5 бүлэг | 60,000 | 300,000 | Орон нутгаараа бахархах сэтгэлийг ярих чадварт суралцана. |
| | 4, 5-р ангийн “Малчны хотонд” | 1 удаа | 4 бүлэг | 57,500 | 230,000 | Мал төллөх үеийн малчдын амьдрал ахуйтай танилцах, өөрийн биеэр ажилд нь туслах, монгол ахуй, сэтгэхүйг төлөвшүүлнэ. |
| | Аймгийн “Харилцан суралцъя” нөлөөллийн уулзалтад бэлтгэх, оролцох | Зохион байгуулалтад | | | 400,000 | СЭЭБХ-ны төслийн болон бусад үйл ажиллагааг танилулж, бусад холбоодоос туршлага судална. Аймгийн удирдлагуудад сургуулийн асуудлыг танилцуулж, |
| | | Замын | | | 100,000 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зардал-5 хүн | | | | шийдвэрлүүлэх үйл явцад оролцно. |
| Үйл ажиллагааны зардал | СЭЭБХ-ны УЗ-ийн уулзалтын зардал | удаа | 10 | 10,000 | 100,000 | Сургалт, чуулга уулзалтын бэлтгэл ажлыг хангана. |
| | Харилцаа холбооны зардал | УЗ-д | | | 200,000 | |
| | Музей байгуулах зардал:<br>- Том номын үзүүлэн хийх<br>-Жааз А4<br>Эцэг эхчүүд хамт макет хийх (сумын үзэсгэлэнт газрууд, ховордсон ургамал, амьтны):<br>-Макет байрлуулах самбар<br>-Брус<br>-Шруп<br>-Гэрэлтүүлэг<br>-Баримлын шавар<br>-Үзэсгэлэнт болон түүхэн дусгалт газар, ховор ургамлын цуглуулга хийх биеэр очиж зурагжуулах замын зардал<br>-Унааны хөлс<br>-Зураг угаалгах | төрөл<br>ш<br>ш<br>ш<br>ш<br>ш<br>ш<br>Км<br>ш | 4<br>2<br>5<br>8<br>50<br>488<br>120 | 80,000<br>80,000<br>25,000<br>40,000<br>3800<br>3000 | 320,000<br>160,000<br>125,000<br>30,000<br>320,000<br>190,000<br>276,000<br>300,000<br>360,000 | 1. Ан амьтад<br>2. Ургамал<br>3. Үзэсгэлэнт газрууд<br>4. Мал ахуйг харуулсан хичээлд хэрэглэгдэх зурган том ном хийнэ (хуанли хэлбэрийн).<br>Үнээтийн булаг Сумаас 80 км, Ханан хад, ханангийн рашаан сумаас 58 км, Яргайт 97 км, Хундар уул-Хүннү үеийн булш 80 км, эмчилгээний далий ягаан цэцэг сумаас 75 км, Дугнарын даваан дахь хүн чулуун хөшөө 98 км. |
| | Урамшуулал | 1 удаа | | | 400,000 | Музей байгуулахад идэвх зүтгэлтэй ажиилаж байгаа эцэг эхчүүдэд урамшуулал олгоно. |
| | Банкны шимтгэл | | | | 36,380 | |
| Бүгд | | | | | 5,287,380 | Монгол банкны ханш: 2643,69 төгрөгөөр тооцов. |

**Хэсэг VI.** Төслийн тогтвортой байдал :

Жил бүрийн сургалтад ашиглана. Ашиглах явцдаа судалгаа шинжилгээ хийж, баяжуулан нэмэгдүүлэх боломжтой. Эцэг эхийн оролцоогоор бүтээлийн санг бүрдүүлж, сургуулийн байгалийн булангаа музей болгох хүртэл ч боломж бий.

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр :

| | |
|---|---|
| СЭЭБХ-ны Зохицуулагч: /Гарын үсэг................................/ | Нэр : Бүргэдээ Эрдэнэчимэг ............ |

| | | |
|---|---|---|
| Төслийг боловсруулсан: | Эцэг эх / Нэр Я.Цолмонсүрэн ..... /................/<br>Эцэг эх / Нэр Ш.Уранзул / ................/<br>Эцэг эх / Нэр А.Цэцэгмаа /................/<br>Эцэг эх / Нэр А.Наранцэцэг/................/<br>Багш:Нэр .Б.Цэцэгмаа /................/<br>Багш / Нэр Ж.Ариунбат /................/<br>Багш / Нэр М.Энх-Амар /................/<br><br>Гарын үсэг........................................... | Огноо:<br>2018оны 11сарын.<br>18.өдөр<br>СУРГУУЛИЙН ЭЦЭГ ЭХИЙН ХОЛБОО |